

“ЭРГҮНЭГУН”-Ы ДОМОГ НЬ ҮНЭН ТҮҮХ БУС УУ?

Хагагин Го.АКИМ

Миний Та бүхэнд толилуулан буй энэ зүйл илтгэл гэхэд илтгэл бус, өгүүлэл гэхэд өгүүлэл бус болсон байж мэднэ. Үүнээс өөрөөр бичиж чаддаггүйг минь өршөөх ажааму.

...Нүхэн даваа өөд бид өгсөж явнам. Бүрэн хаан уул өмнө зүгт мөнгөн дуулгатай наран бурханы гэрэлд гялтагнан байна. Тэгэж явтал Нүхэн даваа ийм нэгэн домог над шивнэвэй.

Эрт урьдын цагт юм гэнэ билээ. Газар дэлхий дээр гайхалтай жигстэй амьтад оришиж, хүн зон агуй ангалд сууж байсан цаг юмсанжээ. Нэгэн залуу анчин шархдуулсан араатныхаа мөрийг хөөсөөр нэгэн гайхамшигтай газар хүрч иржээ. Анчины өгссөн уулын оройд том хад байжээ. Тэр хаданд том нүх байлаа. Шархдсан араатны цустай мөр тэр нүхрүү орсон байвай. Залуу эр үүнийг өөрийнхөө бэлгээр ойлгожээ. Амьд үлдэхийн төлөөх агуу тэмцэлд аль алдаж онохыг хэлж барах вэ. Энэ нь аятай сайхны бэлгэ биш биз. Тэр араатныг мөнх тэнгэр түүнрүү явуулсан юм биш биз? Сумыг зайлуулаад, араатныг шархдуулуулсан, тэгээд түүний мөрөөр түүнийг явуулсан юм биш биз? Залуу анчин хадны нүхээр зоригтой орж явчихав. Тэр гайхалтай ертөнцөд оржээ. Тэrvээр модгүй халзан даваан дээр гарваас өмнө их уулсын хормой эмжсэн моддын дунд дуниартсан шар тал цэлийж байжээ. Тэр талын зүүн захыг эмжин нэгэн их мөрөн хад урсган алдан алласнаа уулын хөндийгөөр мурилзан зүүн хойш далд оржээ. Эргээр нь үргэхийг мэдэхгүй номхон сарлагийн сүрэг бэлчиж байв гэнэ. Сарлагийн саваг нь энэ дагишин газрыг ариусган арчих мэт газар шүргэж байв гэнэ. Залуу анчин сэтгэлээ барьж чадахгүй “тогоо нэрж” орхив. Одоо овог аймгийнхан нь дайнч догишин хөршөөсөө бэргэхгүй, гэдэс хонхолзон өлсөж зовохоос айхгүй болох нь. Залуу эр нутагтаа буцаж ирээд, энэ бүх үзснээ овгийнхондоо ярьж, бүгд тэндээс нүүн мөнөөхөн нууцлаг даваанд хүрч, хадны нүхээр орон, уужим сайхан хөндийд очиж, цаа буга, сарлагийг гаршуулан, амар жаргалтай аж төрөн сууж гэнэ ээ.

Энэ нь уран домог юм. Гэвч домогт түүх буй. Түүхэнд домог буй гэж молхи би мунхагладаг болой. Тийм ээ, энэ бол Нүхэн даваагаар Сэнсийн талд хүн анх очсон тухай домог юм. Гэхдээ тэр хүмүүс хэн байв? Ниндерталууд уу (Neanderthals)? Хомосапиенсууд уу (Homo sapiens)? Эсвэл бүр наашлуулбал Нохос (Nukuz), Хиан (Qyan) нар уу? Сэнсийн тал нь анчны овог аймгаа авч очсон тал мөн гэж домогт өгүүлсэн байнам.

Нүхэн давааны над хүүрнэсэн эл домог Персийн түүхч Рашидаддины “Шашдирын чуулган”-д түүх байдлаар буй. Чингэхдээ энэ шашдирч бүүр “Үнэмшиж болох сурвалжид өгүүлснээр бол...” гэж байгаад бичснийг нь толилуулбал:

“...Өөр аймгууд монгол аймгуудыг дийлж, бүгдийг нь хядахад хоёр эр, хоёр эмээс илүүгүй хүн ам гарсан ажгуу. Энэ хоёр айл дайснаасаа буруулан дутааж, уул, ой модоор хүрээлэгдсэн [нэвтрэхүйеэ] бэрх газарт очиж, тэр нь аль ч талаас нь орохын аргагүй, ер хад чулуутай ганцхан жимээр л хүрч болох тийм газар байжухуй. Энэ уулсын дотор Эргүнэгун гэдэг өвстэй цээл хөндий байж (Гун гэдэг нь уулын хэжүү, эргүнэ гэдэг нь хэрэм, чингэхлээр Эргүнэгун гэдэг нь хэрэм мэт халил гэсэн утгатай). Тэр хоёрыг Нохос, Хиан гэдэг байсан ажаам. Он цаг улиравч тэд хийгээд тэдний үр сад тэндээ байсаар, өвөр хоорондоо гэрлэсээр үржин өсчүхүй. Төрөл бүр нь өөрийн өвөрмөц нэр, цол бүхий

Г.Аким

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн
Natagin@gmail.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

омог болсон авай. Эдгээр омог бас цааш салбарлаж, өдгөө монгол аймгууд хэнийгээ ямар салбараас үүссэнийг, тэр нь нэг нэгэнтэйгээ ямар ойрын хамаатайг тогтоон чадсан ажсаам. Тэд бол дүрлүгин монголчууд юм. Монгол гэдэг үг нь tong ol “ард үл үлдсэн”, “гэнэн хүн” гэсэн утгатай. Монгол хэлээр хиан [qiyan] гэдэг нь улаанаар эргэлдсэн ус, уулаас доош газарт шуугин бууж буй уруй мэт эрчтэй, түргэн, хүчтэй гэсэн утгатай. Хиан нь эрэлхэг, хатан зоригтой байсан тул энэ үг түүний нэр болжухуй. Хиад гэдэг нь хианы олон тоо юм. Уг гарлаараа түүнд ойрхонуудыг нь эрт дээр цагт хиад гэдэг байсан ажгуу.”

“Эргүнэгун гэдэг өвстэй цээл хөндий” нь одоо Сэнсийн тал биш байгаа? Тоймлон өгүүлбээс Зүүн хойт талаараа Зүүн Соёны хөглөгөр их сарьдаг, баруун, баруун хойт талаараа Тагнын огторгуй сүлбэсэн шовх уулс, өмнө талаараа Их Соёны тэнгэр баганадсан данагар их нуруунд хавчигдсан “алга дарам” шаргал тал буй нь одоогийн Сэнсийн тал! Үнэхээр газар шүүрсэн савагтай том том сарлаг билчиж байсаан! Өөрөөр хэлбэл Рашидаддины өгүүлсэн тэр газрын тодорхойлолтод Сэнсийн тал тохироод л байна даа!



...Бид “анчны гаргасан тоом”-оор мухиралдан мацсаар. Бүрэн хаан мөнгөн очис харвуулан, “эд маань яаж шуухан явна даа” гэж халиасаар. Өмнө явсан Даш ламтан гэнэт “хүрээд ирлээ” гэж зарлав. Нэгэн үзүүр тойртол нээрээ элгэн улаан хад моддын дунд цухуйж байвай. Цагаа харвал яг хоёр цаг явжээ. Алдарт нүхэн даваа... Мөнөөхөн анчны өөр ертөнцөд орж омог аймгаа аварсан нүхт хад... Харин Бөртө Чоно нарын далан адуу, үхрийн ширээр хийсэн хөөргөөр хайлуулан гарч ирсэн хад мөн үү? Хадны нүхний байдлыг дороос нь буюу зүүн өмнө талаас нь үзвэл ханан хаднаа дөрөв таван метрийн өндөрт байх ажээ. Тэр нүхээр тэнгэр цэнхэрлэн харагдана. Түүгээр орвол бид тэнгэрт гараад явчих юм биш биз! Гэвч бидний аз дутжээ. Мөлхөхийн заяатай бидэнд нисэхийн хувь дутвай. Бид өгссөөр сэнжит хадны ёроолд очин, мацсаар баруун талынх нь цавчим халилын өмнөх дэвсэг дээр гарав. Анчны гаргасан тоом тэр ханан хад, нүхт хясаа хоёрын хоорондуур мушгиралдан огцом дээш оджээ. Үүгээр гарах өөр зам үгүй. Молхи би дэлхийн дээвэр Жонлунмагийн оргилд гарсан юм шиг баярлаж байлаа. Нүхэн давааны энэ сэнжит хад монголчуудын “хайлуулсан” хад мөн аваас энэ Нүхэн даваа Монголын түүхийн “Жонлунма” даруй мөн...

“Эргүнэ гунд орсон энэ бөлөг иргэн тэр уулсын дунд, ой модны дотор олироод, газар нь давчдах болж, энэ хавчиг шоронгоос гарах арга сүвэгчлэхээр хоорондоо зөвлөлдөжүхүй. Тэд уулнаас [боломж]ийн газар олсон нь, өөрсдийнх нь дандаа төмөр хайлуулдаг байсан

төмрийн уурхай байвай. Тэд цуглаж, ойгоос гишүү, нүүрс авчиран бөөгнүүлээд, дараа нь далан адуу, үхэр төхөөрч, арьсыг нь хуулаад, тэр бүх ширээр дархны хөөрөг хийжсүхий. Хясааны ёроолд мөнөөхөн мөчир, нүүрсийг овоолж, хясааг үйрүүлэн бутлах гэхдээ далан том хөөргөө нэг зэрэг хөөрөгдөж болохуйцаар байрлуулсан ажсаам. Чингээд хэмжээлиггүй их төмөр гаргаж, замыг нээгээд, түүгээрээ гадагш гарсан ажгуу. Тэд уйтан давчуу газраас уужим тэнүүн талд гарч иржсүхий.”

Харин миний дээр өгүүлснээр Рашидаддины тэр “үнэмшиж болох сурвалж нь юу вэ?” Алтан дэвтэр үү, Хасан хааны эрднэсийн санд байсан гар бичмэл үү, эсвэл Хасан хаан өөрөө юу, үгүй бол хамгийг мэдэгч Болод чинсан уу? Үүнийг үл өгүүлэн, хадны нүхний байдлыг дээд талаас нь үзвэл найман ханатай гэрийн буйрын хэр голчтой том хүнхэрхий байна. Гүнээрээ гурван метр хэр болов уу. Хадны нүх тэр хүнхэрийн яг доод амсарт таарч байх ажээ. Морь малтай хүн уг хүнхэррүү буугаад, тэр нүхээр гараад явчихаж өлхөн болохоор. Гэвч цаад тал нь дөрөв таван метрийн эгц хана буй. Буух аргагүй. Тэр үед бууж болж ч байсан юм билүү, хэн мэдлээ. Мянга шахам жилд чулуу нурах, хад хагарах, жим балрах гээд юу эс болох вэ? Харин жим балраагүй байна гэж молхи би мунхагламуу. Учир нь зам харгуй байгаагүй үед эндхийнхний Аха ордог цорын ганц зам нь бидний мацаж ирсэн жим байжээ. Бөртэ чонын гаргасан зам биш үү? Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “ Алтан товч”-доо

Мандал сайвар одогсдын эртний гагц эцэг

Манзушир бодьсадын нигүүлсэхүй салбар

Манлай эрхэм мөнх Бөртэ чоно хэмээгч

Манай энд заларч ирснийг мэдэгтүн

гэж нэгэн сул шүлгийг шигтгээд, “Бөртэ чонын хорин есний хөвгүүн Батачи хан нь Тан улсын Дэ Цзуны Чжан Юань-ий хоёрдугаар он, улаан барс жил төрөв” гэж буй. Энэ он нь манай тооллын 786 он юм. Батачи хан Бөртэ чонын хорин есний жилд гарсан болохоор 786-гаас 29-ийг хасвал 757 болно. Чингэхлээр Бөртэ чоно 757 оны хүн байна. Жамбалдоржийн “Болор толь”-д ч Тан улсын үед амьдарч байсан гэж буй. Энэ нь манай эриний 610-907 онд тохирно. Чингэхлээр түүнээс хойш 1250 орчим жил өнгөрчээ. 1000 жилд хөрс доош суух ч юм уу, хад нурах ч юм уу, юу эс болох вэ? Молхи би яагаад Бөртэ чоныг дурдаад байна вэ? Манай зарим мэргэд МНТ-д нэр дурдагддаг Бөртэ Чоно, Хоо маралыг домгийн баатар гэж үзэх нь бий. Гэтэл молхи би огт өөр бодолтой байдаг болой. Тэд бол чоно ч бус, марал буга ч бус, бодтой аж төрж байсан түүхэн хүмүүс мөнөөс мөн. Өөрсдийнхнийхээ бичснээс сийрүүлэхээ больё. Рашидаддиныг дахин нэг ишлээд үзье. Тэр бичсэн нь, “Түрэгийн үнэн үгтэй түүхчид тэмдэглэхдээ, монгол аймгууд Эргүнэ гунд орсон хоёр хүнээс үүссэн гэнэ. Тэндээс гарч ирсэн тэдний нэг нь аймгийн эзэн, нэр нөлөөтэй цэргийн ноён Бөртэ Чоно байж... Бөртэ Чоно Хоо Марал нэрт их эхнэрээсээ нэгэн хөвүүнтэй, тэр нь хөвүүдийнх нь дотроос хааны зиндаанд хүрсэн хамгийн нэр нөлөө бүхий хүн байвай. Түүнийг Батачи хиан гэмүй” гэжээ. Мөн Чингис хааны ахмад хөвүүн Жочийн 12-р үеийн удмын Абалгази хаан өөрийн *Монгол хаадын товчоон*-доо “Эдгээр ард Эргүнэ Хунаас гарахад батачи нь хорилос овгийнхны Бөртчина...” гэж бичсэн байна. Бас Оросын Н.Я.Бичүрин эрдэмтний бичснийгсийрүүлсү. “Энэхүү уулын хавцал сэтлэн гарсан овог аймгууд нь ЭргүнэГунгаас өөрсдийн өвөг дээдсийн хуучин нутгийг тэмцэн одсон бөгөөд тэднийг Бөртэ чоно хаан удирдан явсан байна” гэжээ. Энэ гурваас үзэхэд л Бөртэ Чоно маань биетэй бодтой түүхэн баатар байгаа биз дээ. Жагарын “есөн эрдэнийн нэг” гэж дээдлэгддэг Абул Фазал “Акбарнама”-даа “Эргүнэгунаас монголчууд Юлдүз ханаар удирдуулан гарсан” гэж буйг сонирхуулах нь зүй. Энэ нь ч Эргүнэгунаас монголчуудын гарсан нь домог бус, түүх гэдгийг давхар харуулнам бус уу.

Эргүнэгуны хаа байгаа тухайтад мэргэдийн санал өнөө болтол тогтсон юмгүй. Хүн хүний бодол, гүзээ гүзээний булан л бий. Өөрөөр хэлбэл дөрвөн санал буй. Нэгдэх нь гэвэл, Оросын түүхч Грумм Гржимайло “Эргүнэгун лугаа төсөөтэй газар Дорнод Азид байхгүй, ганц Енисейн эхний гол нь зүг бүрээс өндөр уулаар хүрээлэгдээд, дорно зүгээс хүн явшгүй ой тайгаар бүсэлсэн, гадагш нэвтрэн гарах ба ороход түмэн бэрхтэй газар тул Эргүнэ гун

лугаа адилтгаж болох мэт боловч монгол аймгийн язгуур нутгийг эрэлхийлэхэд Эргүнэгун хэмээн өгүүлэх түүхийг хэрэгсэхгүй орхивоос зохино” гэжээ. Өөрөөр хэлбэл, нэлээд баруугаар Енисейн эх рүү заасан хэрэг юм. Хоёрдох нь гэвэл Монголын түүхч А.Амар сайд Зүрхийн халуун рашаанд орохоор очоод “Охид, хүүхэд” гэдэг уулыг ойрын уулан дээрээс хараад гайхамшигтай сүрлэг уул болохыг үзэж, нутгийн хамниган өвгөдтэй уулзаж, яагаад тийм нэртэй болсныг асуусан байна. Тэгтэл миний дээр өгүүлсэн “Шашдирын чуулган”-д өгүүлсэнтэй төсөөтэй домгийг хамниганы өвгөд түүнд ярьж өгчээ. Хүүрнэсү.

Эрт нэгэн цагт хамниган үндэстэн бусдад хядагдан алагдаад, ганц нэгэн айл хүмүүс охид хүүхдээ авчирч, энэхүү ууланд тавиад буцаж, гэр малаа авахаар явсан нь бас дайснаа алагдсан тул тэрхүү охид хүүхэд нь үхэлгүй хүмүүжиж олон болсоор багталцахгүй болж эргэн тойрон дахь нэгэн төмрийн уурхайт хадыг их түлээ овоолж, галдан хайлгаж урсгаад гарсан хэмээдэг тул үүний учраар Охид хүүхэд хэмээн нэршсэн гэдэг.

Амар гуай цааш нь бичихдээ, “дээр дурдсан Эргиний хун хэмээгч нь эрхбиш үүнийг хэлсэн мэт бөгөөд Эргэний хун хэмээсэн нь лав одоо хүртэл нэрлэгдэн буй Хунгийн голоор тийнхүү нэрийдсэн буй заа” гэжээ. Чухамхүү энэ газар хаа байгааг Амар гуай заахдаа “Онон, Хэрлэн, Зүрх, Минж зэрэг олон голуудын товчлох Хэнтийн нурууны баруун үргэлжлэл болох “Охид, хүүхэд” хэмээх нэгэн их өндөр уул бий. Энэхүү... уул болбаас олон их нурууны дээр эргэн тойрон хүрээлэгдэн тогтсон нь түүний аль ч талаас хүн гарч ороход бэрх цавчим эгц тийм нэг газар буй бөгөөд нэгэн үүд мэт нам газраар гөрөөчин хүн орж үзвээс, түүний дотор их л уудам зайтай, ихэхээн хот хүрээ багтаж болмоор хэмээх ба түүний ар доороос Хунгийн гол хэмээх их гол урсаж гараад Шаралун хэмээн гол лугаа нийлж, Зүрх гол болон умард тийш урсана” гэжээ. Иймд Амар сайд Эргүнэгунг Хэнтийн нурууны хойт үзүүр рүү, нэлээд зүүгээр заажээ. Гуравдахь нь гэвэл, өнөөгийн Зүүн хойт Хятадад буй Эргүнэ мөрний хавь газар юм. Өвөр Монголын Сайшаал эрдэмтэн бичихдээ: “Эргүнэ хун гэдгийг одоо эрдэмтэд “Эргүнэ гол” гэж үзэж байна. Эргүнэ гол бол Хөлөн нуураас эх авч, Хар мөрөнд нийлж бүхий Номхон далайн усан системийн нэгэн гол юм. Нутгийн ардын уламжлалт яриа нь “Өргөн гол” гэдэг үгээс үүссэн нэр гэдэг” гээд Элдэндэй эрдэмтний Хөлөн буйр аймгийн доторхи зарим монгол түүхэн газрын нэрсийн тухай магадлалт” гэсэн өгүүллээс ишлэсэн нь “Өвөр Монголын Хөлөн буйр аймгийн нутаг дахь Биньчжоу төмөр зам (Харбинаас Манжуур хүрэх) дээр нэгэн “Жалө-мү-дэ” гэдэг галт тэрэгний өртөө буй. Түүнээс баруунш бараг, найм, есөн км зайтай арван зургадугаар халааны өртөө гэж байдаг. Энэхүү халааны өртөөнөөс хойгуур, Хайлаар гол зүүнээс баруунш урсаж байна. Голын араар нь уул нуруу үргэлжилсэн довтог газар юм. Түүний дотор нэгэн хорь, гучин метр өндөр цавчим хад буй. Нутгийн ард үүнийг “Эргин хад” гэдэг” гэж бичсэн байна. Энд хятадууд олон улсын зочидыг татах маш том цогцолбор байгуулж байна. Тэр ч байтугай манай “Монгол Улсын түүх”-энд ч Эргүнэ гуныг Аругуны нуруу буюу Эргүнэ мөрнийг гэж бичсэн ажээ. Дөрөв дэх нь эл Аха нутаг мөн. Буриадын эрдэмтэн П.Б.Коновалов, Буриад улсын Төрийн шагналт зохиолч, хэл бичгийн ухааны доктор Б.С.Дугаров, Н.Г.Доржиев нарын бүрэлдэхүүнтэй эрдэм шинжилгээний анги Ахын нутагт очиж үзээд, энэ бол монголчуудын сууж байсан домогт Эргүнэгун” байж магадгүй гэсэн дүгнэлт хийсэн байна. Гаргасан үндэслэлүүд нь жаахан мөчид гэмээр. Гэвч би тэдэнтэй маргахыг үл хүснэ. Молхи бичээч би өөрөө ч нэг их сүртэй амьтан биш. Харин энэ газрыг нүдээр үзэж байгаагийн хувьд монголчуудын авралын орон болсон ариун Эргүнэгун мөн байна гэж л хэлэх гээд байна даа. Нүд үнэнч, чих худалч гэдэг. Гэвч яагаад тэгэж хэлэх гээд байна вэ?

...Бид жимээ түр алдав. Явгаан маань “бид буруу явж байна, энэ гахайны гаргасан жим байна” гэдэг байгаа. Молхи би гахай газар хадардагаас биш, жим гаргадгийг дуулаагүй ч үгэнд үнэмшиж байгаа ч юм уу жимээсээ ялихгүй хазайж, явсаар цавчим халилд тулав. Сохорсон биш завшив гэгч боллоо. Нүдний өмнө цэлсхийсэн нь, Хар, Цагаан Эрхүү уулзалдаад, их уулсын дундуур угалзлан алсалад, Ангар мөрөнтэй тэврэлдэн, их усаа Хойт мөсөн далайд хүрэхээр одож байна.

Эрхүү хархүү Ангар бүсгүйд сэтгэлтэй болжээ. Гэтэл Байгаль эцэг Ангар бүсгүйг

Эрхүүд өгөхөөс татгалзаж, хилгэнэхдээ бүсгүйн замыг хаан нэгэн том чулууг түүний мөрт чулуудсан гэнэ. Гэвч хайр сэтгэлийг дийлэх хүч хаана байх вэ, Ангар бүсгүй уг чулууг тойрон гарч, Эрхүүтэй нийлэн, умар зүг одсон гэнэ.

Эрхүү ...Эргү-нэ... Монгол бичгээр бичвэл эдгээр үгийн үндэс ав адилхан бичигдэнэ. Тийм ээ, монгол бичгээр бичихэд, **эрхү** ч гэж, **эргү** ч гэж уншиж болно. Хэл шинжлэлийн үүднээс үзэхэд ийм юм. Ийнхүү Эргүнэгийн нэрийг өдгөө хоёр Эрхүү хадгаланхан урсана биш үү?! Өөрөөр хэлбэл Рашидадины өгүүлсэн тэр газрын тодорхойлолтод Сэнсийн тал тохироод л байна даа. Грумм Гржимайло “Эргүнэгун лугаа төсөөтэй газар Дорнод Азид байхгүй” гэсэн боловч над бол Сэнсийн тал нь эргүүлгэн их уулсаараа шашдирын Эргүнэ гуныг санагдуулаад л байна даа. Өнөөгийн шинжлэх ухааны хэлээр хэлбэл, газар зүйн байрлалаараа гэх юм уу да. Энэхүү Сэнсийн талд байсан эртний булшны хэдэн зургийг авч ирээд, археологич Д.Эрдэнэбаатаргаа үзүүлбэл “Нэг нь яахын аргагүй эртний монгол булш байна” гэж дуу алдлаа. Энэ булш ганцаараа бус нь тодорхой. Эртнийдээ хэдий үеийнх вэ? Мөн эргүүлгэн булш хэнийх вэ? гэх мэт олон асуулт таамаг төдий үлдэв. Тэр бүхнийг археологийн судалгаагаар л тогтоох нь дамжиггүй. Рашидадин “Монгол хэлээр *хиан [qiyān]* гэдэг нь улаанаар эргэлдсэн ус, уулаас доош газарт шуугин бууж буй уруй мэт эрчтэй, түргэн, хүчтэй гэсэн утгатай. *Хиан* нь эрэлхэг, хатан зоригтой байсан тул энэ үг түүний нэр болжухуй” гэснийг дээр дурдсан. Өнөөгийн Ахын голыг буриад аялгуугаар **Ахайн** гэнэ. **Х**-гийн өмнөх **а**-г нь авчихвал *хаин* болно. *Хиан*тай мөн ч төстэй дууддаж байна аа даа. Зөвхөн төстэй дууддаж байгаа нь шинжлэх ухааны баталгаа болж чадахгүй л дээ. Гэвч би батлах гэж оролдсу. **Х**-гийн өмнө эгшиг нэмэгдэх үзэгдэл монгол хэлнээ элбэг тохиолдоно. Ганцхан жишээ дурдахад, Хоо Маралын **Хоо**-г халх аялгуунд *ухаа* гэж өдгөө дууддаж байгаа. Өөрөөр хэлбэл, **-х** гийгүүлэгчийн өмнө **у**-эгшиг нэмэгдэж. Арынх нь **-оонь** **-аа** болчихож. Аман аялгуунд шүү дээ. Тэгвэл дүрвэд, урианхай аялгуунд **хоо** гэдгээрээ байгаа. Зарим хүн **хайн** бус **хиан** байна гэж маргаж болох ч **оо** нь **аа** болж байхад **иан** нь **айн** болоход энүүхэнд гэж өөрийгөө өмөөрч болно. Мянга долоон зуу гаруй жилд хэлэнд ямар ч хувирал гарч болох гэж мунхагламуу. Ер монголчууд уул усаа хүнээр нэрлэх, уул усныхаа нэрийг хүнд өгөх нь ерийн юм. Ухаан нь, Атилла хааны нэр нь Итил буюу Ижил мөрний нэр гэнэ. Үүнийг Мажарын монголч эрдэмтэн БорболаОбрушинский Улаанбаатарт уншсан нэгэн лекцэндээ өгүүлж байсан. Мөн домог ч бай, үнэн ч бай, далан бухын ширэн хөөргөөр хайлуулан шургасан ч бай, дайчин овгоо дагуулсаар хажуугийнх нь тоомоор шүргэн өнгөрсөн ч бай, Бөртэ чоныхны гарч ирсэн гэгдэх морьтой хүн элбэгхэн багтах нүхтэй хясаа Нүхэн даваа нэртэй болоод энд байгаа юм биш үү? Нүхэн даваа гэдэг нэрийн учрыг тайлсан нэгэн өгүүлбэр *Шашдирын чуулган*-д буйг сийрүүлбээс “...Чамчал (монголоор Цавчаал) гэдэг нь **Нүхэн даваа** гэсэн үг бөгөөд уул сэтэлж гаргасан гарц” гэжээ. Үүнийг үл өгүүлэн өгүүлэхэд, Эрхүү голыг уруудахад Ихгун, Халагун, Харагун нэрт цутгалангууд түүнд шуугин ирж нийлнэ. Эдгээр **зун** нь Эргүнэ**зун**гийн **-зун**-ыг зааж байгаа юм биш биз ээ?! Өдгөө бид монголчууд гэж дэлхийд нэрээ дуурсгаж яваа нь өвгө дээдсийг маань өвөртөө нуусан Эргүнэгун хэмээх ээлтэй орны ач болой! Соёд зоны маань гал голомтоо сахиж, аж төрөн суугаа энэ газар! Ачтай ээлтэй энэ газрыг Чингисийн алтан ургийнхан мартаагүй байдаг. “Алун гоогийн эр Добун баян хианаас, Алун гоо нь гороласаас гарсан, дээр өгүүлснээр Чингис хааны уг сурвалж тэдэнрүү эргэж байгаа учир төмөр хайлуулах буюу төмөр дархлахыг үл умартмуу заа. Шинэ он шилжрэн ирэхүйд шөнө нь Чингис хааны ургийнхан дархцуулыг цуглуулж, дарханы хясаа, модны нүүрс авчирч байгаад, хэсэг төмрийг улайсгаснаа дөшин дээр тавиад алхаар сунган давтаж, [уулнаас гарсан]даа баярлаж байгаагаа илэрхийлдэг заншилтай ажгуу” гэж Рашидадин бичжээ. Бид ч умартах учиргүй юм аа. Тийм ээ, би Монголчуудыг үлдсэн Эргүнэгун энэ байна гээд дахиад нэг хэлчихье.

Тэгтэл бас Бөртэ чоно “хад хайлуулж” Эргүнэ гунаас гараад, хаашаа эргэсэн бэ?, Бурхан халдунд хэрхэн ирсэн бэ? гэсэн хэд хэдэн асуулт гардаг. *МНТ*-д “Тэнгис гаталж ирэв” гэсэн байгаа. Тэр “тэнгис” хаана байна вэ, гол уу, жинхэнэ тэнгис үү? Номч мэргэн Ринчен багштан Лев Гумилев эрдэмтэнд бичсэн нэгэн захидалдаа Хөвсгөлийн Шишигэд

хавьд байх Тэнгис нэрт уулын голыг гэсэн нь бий. Ингэхлээр Нүхэн давааг Бөртэ чонын гарч ирсэн даваа мөн гэж үзвэл тэднийхэн эндээсээ чанх баруун тийш эргэсэн болж таарч байгаа юм. Гэтэл эндээс шууд баруун тийш эргэх ямар ч боломж байхгүй. Хөлгүй шахам анаг ангал тулна. Цагаан Эрхүүг даган явж байгаад нэлээд доогуур баруун тийш эргэх зам олсон байж болох боловч мөрт нь Хөвсгөл нуур, нуурт цутгадаг уулын олон ширүүн голыг гатлаж, Тэнгис голд хүрээд, гатласан бол баруун тийш гатласан байж таарна. Зүүн тийшээ биш! *МНТ*-д бол тэдний зам зүүн урагш чиглэж, Тэнгис гатлаад Бурхан халдунд ирсэн тухай өгүүлээд байгаа. Мөн өч төчнөөн уулын урсгаад одох ширүүн гол мөрт нь таарч байхад ганц Тэнгис голыг дурдана гэдэг хачирхалтай. Иймд молхи миний бодлоор бол Эрхүү голыг даган уруудсан биз ээ. Хар, Цагаан Эрхүү нийлээд Эрхүү болон доош урсахад хөндий нь ихээ уужимсана. Ийнхүү Бөртэ чоно гэргий Хоо маралын хамт албат иргэдээ дагуулаад Эрхүү голыг даган уруудаж, Ангар мөрөн хүрчээ. Тэгээд Байгаль нуурыг ямар нэгэн байдлаар гатласан байна. “Дундад зууны үед монгол хэлт түмнүүд нуурыг Тэнгис, Тэнгис далай гэж нэрлэж байсан, энэ нь яваандаа Байгал гэдэг үгэнд шахагдсан”, “Байгал гэдэг нэр хожуу, XVII зуунаас хойш л үүссэн” гэж Оросын эрдэмтэн С.А.Гурулев бичсэн байна. Мөн “Тэнгис нэрийг хүн [хүннү] нар хэрэглэж байсан, эл үг хүн нарын үгсийн санд орсон байсан” гэж Т.А.Бертагаев бас бичсэн нь бий. “Эвенк аялгуугаар Байгалийг *Лама* гэдэг, энэ нь мөн *тэнгис* гэсэн үг гэж М.Н.Мельхеев эрдэмтэн бас бичсэн байна. Тэр байтугай Монголын нууц товчоо-г англи хэлээр орчуулсан Игорде Рахвилц нэлээн эргэлзэнгүй боловч Тэнгис гэдгийг Байгаль нуур гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Ишилсү. “Бөртэ Чоно, Хоо Марал гэсэн домогт дээд өвгө Бурхан халдун ууланд Тэнгис (? Байгаль нуур) гатлаж иржээ” Чингэхлээр Бөртэ Чонын үед Байгал нуурыг Тэнгис гэж байсан нь тодоос тод байна. Энэ бүхнээс үзэхэд хатагнины Ц.Дамдинсүрэн эрдэмтэн “Монголын нууц товчоо”-г эртний монгол хэлнээс өнөөгийн монгол хэлрүү хөрвүүлэхдээ тэнгис гэдэг дээр далай гэдэг үгийг нэмж “тэнгис далай” гэсэн нь бас учиртай байна. Ер Эргүнэгунаас гарч ирсэн гэгдэх олон овог Байгаль орчмоор нутаглаж байсан тухайтад *МНТ* болон *Шашидирын чуулган*-д тов тодорхой өгүүлсэн бий шүү дээ. Иймээс молхи би ямар гаргалгаа хийж байна вэ? гэвэл Эргүнэгун бол Сэнсийн тал байна, Бөртө чонын хайлуулж гарсан гэх хад нь Нүхэн даваа байна, Тэнгис гэдэг нь Байгаль нуур байна гэсэн гаргалгаа хийж байна. Тийм ээ, Эргүнэгунгийн домог гэдэг нь үнэн түүх байна!

...Явсан нохой яс зуудаг юм гэнэ билээ. Сэнсийн тал, Нүхэн даваагаар явсан нохой миний зууж ирсэн “яс” ийм болой.

Ашигласан ном зохиол

1. Рашидаддин. *Шашидирын чуулган*. Англи хэлнээс орчуулж, Уялга үг бичиж, тайлбар зүүлтийг үйлдсэн Хатагин Го.Аким. УБ., 2013.
2. *Монголын нууц товчоо*. Шинээр хөрвүүлж, тайлбар үйлдсэн доктор, профессор Ш.Чоймаа. УБ., 2011.
3. А.Амар. *Монголын товч түүх*. УБ., 1989.
4. Р.Сайшаал. *Чингис хааны товчоон*. Дээд дэвтэр. УБ., 2004.
5. *Монгол Улсын түүх*. УБ., 2004.
6. А.Б.Иметхенов, Б.Д.Шарастепанов, О.А.Иметхенов. *Горная Ока*. География Восточного Саяна. Улан-Уде. 2008.
7. С.А.Гурулев. *Что в именитвоем, Байкал?* Новосибирск. 1982.
8. Чингис, Жочийн удам Абалгази баатар хаан. *Монгол төрийн товчоон*. УБ., 2007. Хасаг хэлнээс Цэрэндорж монгол бичгээр орчуулж, Н.Нагаанбуу, Б.Элбэгзаяа нар орос үсгээр буулгажээ.
9. Абу-л-Фазл. *Акбар Намә*. Calcutta, 1907.
10. Г.Е.Грумм Гржимайло. Западная Монголия и Урянхайский край. Т. III. Л.-Ленинград. 1927.

SUMMURY

In the paper, I attempted to prove one legend as a true story. In my opinion, legends contain history and history contains legends. As I myself travelled through “Сэнсийн тал” and “Нүхэн даваа” and explored the data related to them, I thought and felt that a legend of Ergune Gun - the place, from which first Mongols were originated, was a true story. In other words, I thought that the present “Сэнсийн тал” is then Ergune Gun, because, as I see, “Сэнсийн тал” conforms to the description about that place did by Rashidaddin.

In order for the proof, I used the notes in ancient historical treatises and tracts as “Шашдирын чуулган” by a Persian historian Rashidaddin, “Алтан товч” by Gash Sacred Luvsandambijaltsan, “Болор толь” by Jambaldorj, “Монгол хаадын товчоон” by Abalgazi khan and some other notes and evidences by the scholars as Russian scholars N.Ya.Bichurin, S.A.Gurulev, T.A.Bertagaev, M.N. Meliheev, scholars Igorde Rahvilts and Ts. Damdinsuren.

At present scientists haven't agreed on the fact where that Ergune Gun is located and there have been four different suggestions on this issue. The first one was done by a Russian historian Grumm Grjumailo. He said that the place similar to Ergune Gun doesn't exist in Eastern Asia and so this story shouldn't be neglected. The second one was done by a Mongolian historian, ex-prime minister A.Amar. He said Ergune Gun is located in the north-east edge of Khentii mountain ranges. The third one by an Inner Mongolian researcher Saishaal is that it is located around Ergune River in North-eastern China. The forth one by Buriad scientists P.B.Konovolay, B.S.Dugarov and N.G.Dorjiev is that it is an Aha area. In my point of view, their evidences are a little mediocre and here I comprehensively described my evidences.

Furthermore, some scholars consider that Burte Chino and Hoo Maral mentioned in “The Secret History of Mongol” were legend heroes, but I think they were real people and here I attempted to give some evidences from reasonable sources.